



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

┌ Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг ┐  
шинэчлэн тогтоох, төвлөрүүлэх журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 26.2.13, Даатгалын тухай хуулийн 14.2.17, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг нэгдүгээр хавсралтаар, Даатгалын байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хоёрдугаар хавсралтаар, Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг гуравдугаар хавсралтаар, Хадгаламж, зээлийн хоршооноос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг дөрөвдүгээр хавсралтаар, “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг төвлөрүүлэх журам”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг шинэчлэн батлах тухай 291 дүгээр тогтоол, 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох журам” батлах тухай 267 дугаар тогтоол, 2014 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн “Үнэт цаасны зах зээлд оролцогчдоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг шинэчлэн тогтоох тухай” 262 дугаар тогтоол, 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Хадгаламж, зээлийн хоршооноос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай” 349 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

83070

3. Энэхүү тогтоолын тавдугаар хавсралтын 3.1 дэх хэсгийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан өөрийн дүрэм, журам, төлбөр тооцооны програмд зохих өөрчлөлтийг хийж, бэлтгэл ажлыг ханган энэ талаарх мэдээллийг Хороонд ирүүлэхийг зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх үүрэг бүхий этгээдүүдэд үүрэг болгосугай.

5. Батлагдсан журам, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 158 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДЭЭС ТӨВЛӨРҮҮЛЭХ  
ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

УХА0410 5043239

	Зохицуулалттай үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
<b>НЭГ. Тусгай зөвшөөрөл</b>			
1.1	Брокерийн үйл ажиллагаа	Хувьцааны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0.04 хувьтай тэнцүү	Тухай бүр
		Хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцлээс олсон шимтгэлийн орлогын 10.0 хувьтай тэнцүү	Тухай бүр
1.2	Дилерийн үйл ажиллагаа	Хувьцааны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0.04 хувьтай тэнцүү	Тухай бүр
		Хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцлээс олсон шимтгэлийн орлогын 10.0 хувьтай тэнцүү	Тухай бүр
1.3	Андеррайтерийн үйл ажиллагаа	2,000,000.00 төгрөг	Жил бүр
1.4	Төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, өмчлөх эрх бүртгэх үйл ажиллагаа	Үнэт цаасны биржийн арилжааны хэлцлийн үнийн дүнгээс зохицуулалттай этгээдүүдийн авсан шимтгэлийн орлогын 10.0 хувьтай тэнцүү	Тухай бүр
1.5	Кастодианы үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	500,000.00 төгрөг	Тухай бүр
1.6	Кастодианы үйл ажиллагаа	1,000,000.00 төгрөг	Жил бүр
1.7	Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа	Үнэт цаасны биржийн арилжааны хэлцлийн үнийн дүнгээс зохицуулалттай этгээдүүдийн авсан шимтгэлийн орлогын 10.0 хувьтай тэнцүү	Тухай бүр
1.8	Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа	1,000,000.00 төгрөг	Жил бүр
1.9	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа	1,000,000.00 төгрөг	Жил бүр
1.10	Санхүүжих чадавхийн зэрэглэл тогтоох үйл ажиллагаа	1,000,000.00 төгрөг	Жил бүр
1.11	Үнэт цаасны итгэмжлэн удирдах	500,000.00 төгрөг	Жил бүр

<b>ХОЁР. Бүртгүүлэх үйл ажиллагаа</b>			
2.1	Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх	100,000.00 төгрөг	Жил бүр
2.2	Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх	100,000.00 төгрөг	Жил бүр
2.3	Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх	100,000.00 төгрөг	Жил бүр
2.4	Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх /Холбоо, Бирж, ҮЦГТТХТ/	200,000.00 төгрөг	Тухай бүр
2.5	Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэх	1,000,000.00 төгрөг	Тухай бүр
<b>ГУРАВ. Хуульд заасан бусад зөвшөөрөл</b>			
3.1	Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ	500,000.00 төгрөг	Жил бүр
3.2	Зэрэглэл тогтоох үйл ажиллагааг бүртгэх	1,000,000.00 төгрөг	Жил бүр
3.3	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах зөвшөөрөл	500,000.00 төгрөг	Тухай бүр
3.4	Харилцагчийн нэгдсэн данс эзэмших зөвшөөрөл /номинал/	500,000.00 төгрөг	Тухай бүр
<b>ДӨРӨВ. Үнэт цаас гаргагчидтай холбоотой</b>			
4.1	Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж бүртгүүлэх /Хэлбэр өөрчлөх, нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах болон үнэт цаас нэмж гаргах, хувьцаа хуваах, нэгтгэх/	200,000.00 төгрөг	Тухай бүр
4.2	Шинээр үнэт цаас бүртгүүлэх	500,000.00 төгрөг	Тухай бүр
4.3	Үнэт цаасыг бүртгэлээс хасах	200,000.00 төгрөг	Тухай бүр
4.4	Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг Монгол улсын үнэт цаасны бүртгэлд бүртгэх	500,000.00 төгрөг	Тухай бүр
4.5	Монгол улсын хуулийн этгээдээс гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх	500,000.00 төгрөг	Тухай бүр
4.6	Үнэт цаас гаргагчийн оноосон нэр өөрчлөх	500,000.00 төгрөг	Тухай бүр
<b>ТАВ. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа</b>			
5.1	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	3,000,000.00 төгрөг	Тухай бүр



5.2	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа /тусгай зөвшөөрөл олгосон жил энэ хөлсийг төлөхгүй/	1,000,000.00 төгрөг	Жил бүр
5.3	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа	1,000,000.00 төгрөг	Жил бүр
5.4	Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа	500,000.00 төгрөг	Жил бүр
5.5	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх үйл ажиллагаа	1,000,000.00 төгрөг	Жил бүр
<b>ЗУРГАА. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ</b>			
6.1	Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод салбар нээх зөвшөөрөл	100,000.00 төгрөг	Тухай бүр
6.2	Орон нутагт салбар нээх зөвшөөрөл	20,000.00 төгрөг	Тухай бүр
6.3	Тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн оноосон нэр өөрчлөх	500,000.00 төгрөг	Тухай бүр
6.4	Тусгай зөвшөөрлийг сэргээх	100,000.00 төгрөг	Тухай бүр
6.5	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000.00 төгрөг	Тухай бүр
<b>ДОЛОО. Биржийн бус төлбөр тооцоо</b>			
7.1	Биржийн бус үнэт цаасны хэлцлийн дагуу өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулах /Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэх, өвлүүлэх, өмчийн эрхийг шилжүүлэх, шүүхийн болон шүүхийн гүйцэтгэлээс бусад журмаар үүргийн гүйцэтгэлийг хангах үед гарах үнэт цаасны өмчлөх эрхийн өөрчлөлт болон Засгийн бонд, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өмчлөх эрхийн өөрчлөлт гэх мэт/	Үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн орлогын 20.0 хувьтай тэнцүү	Тухай бүр
<b>НАЙМ. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /ХААБ/-ийн тусгай зөвшөөрөл</b>			
8.1	Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	100,000.00 төгрөг	Тухай бүр
8.2	Тусгай зөвшөөрөл сунгах	100,000.00 төгрөг	Тухай бүр
8.3	Спот арилжаа хийх зөвшөөрөл	100,000.00 төгрөг	Жил бүр
8.4	Дериватив арилжаа хийх зөвшөөрөл	100,000.00 төгрөг	Жил бүр
<b>ЕС. ХААБ-ийн Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ</b>			
9.1	Салбар нээх зөвшөөрөл	100,000.00 төгрөг	Тухай бүр
9.2	Оноосон нэр өөрчлөх	100,000.00 төгрөг	Тухай бүр

9.3	Тусгай зөвшөөрлийг сэргээх	100,000.00 төгрөг	Тухай бүр
9.4	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000.00 төгрөг	Тухай бүр
9.5	Хөдөө аж ахуйн биржийн арилжааны шимтгэл	Арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0.04 хувьтай тэнцүү	Тухай бүр

----- о 0 о -----

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 158 дугаар тогтоолын хаврдуугаар хавсралт

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГААС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

УХА0410 5043239

	Зохицуулалттай үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
<b>НЭГ. Тусгай зөвшөөрөл</b>			
1.1	Ердийн даатгалын үйл ажиллагаа /тусгай зөвшөөрөл олгосон жил 3,000,000.00 төгрөг төлнө/	Өмнөх оны даатгалын цэвэр хураамжийн орлого 3.0 тэрбум төгрөг хүртэл бол цэвэр хураамжийн орлогын 0.65 хувьтай тэнцүү /доод хэмжээ 3,000,000.00 төгрөг/	Жил бүр
		Өмнөх оны даатгалын цэвэр хураамжийн орлого 3.0 тэрбум төгрөг болон түүнээс дээш бол цэвэр хураамжийн орлогын 0.55 хувьтай тэнцүү /доод хэмжээ 3,000,000.00 төгрөг/	Жил бүр
		Өмнөх онд давхар даатгалд төлсөн хураамжийн 0.3 хувьтай тэнцүү /доод хэмжээ 3,000,000.00 төгрөг/	Жил бүр
1.2	Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа	5,000,000.00 төгрөг	Жил бүр
1.3	Давхар даатгалын үйл ажиллагаа	5,000,000.00 төгрөг	Жил бүр
1.4	Улаанбаатар хотод даатгалын зуучлагчийн мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа	300,000.00 төгрөг	Жил бүр
1.5	Орон нутагт даатгалын зуучлагчийн мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа	150,000.00 төгрөг	Жил бүр
1.6	Даатгалын хохирол үнэлэгчийн мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа	Даатгалын хохирлын үнэлгээний хураамжийн орлогын 0.55 хувьтай тэнцүү /доод хэмжээ 300,000.00 төгрөг/	Жил бүр
<b>ХОЁР. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ</b>			
2.1	Улаанбаатар хотод даатгалын мэргэжлийн оролцогч компани салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл	100,000.00 төгрөг	Тухай бүр

2.2	Орон нутагт даатгалын мэргэжлийн оролцогч компани салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл	20,000.00 төгрөг	Тухай бүр
2.3	Улаанбаатар хотод даатгалын компани салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл	200,000.00 төгрөг	Тухай бүр
2.4	Орон нутагт даатгалын компани салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл	20,000.00 төгрөг	Тухай бүр
2.5	Даатгалын компани, мэргэжлийн оролцогчийн оноосон нэр өөрчлөх	500,000.00 төгрөг	Тухай бүр
2.6	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000.00 төгрөг	Тухай бүр

----- о 0 о -----



Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 158 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ**

УХА0410 5043239

	Зохицуулалттай үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
<b>НЭГ. Тусгай зөвшөөрөл</b>			
1.1	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа /Нийт активын дүнгээс өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг хассан дүн/	4,000,000,001.00 төгрөгөөс дээш бол	2,600,000.00 төгрөг Жил бүр
		2,000,000,001.00-4,000,000,000.00 төгрөг хүртэл бол	2,200,000.00 төгрөг Жил бүр
		1,000,000,001.00-2,000,000,000.00 төгрөг хүртэл бол	1,600,000.00 төгрөг Жил бүр
		600,000,001.00-1,000,000,000.00 төгрөг хүртэл бол	1,200,000.00 төгрөг Жил бүр
		400,000,001.00-600,000,000.00 төгрөг хүртэл бол	800,000.00 төгрөг Жил бүр
		200,000,001.00-400,000,000.00 төгрөг хүртэл бол	600,000.00 төгрөг Жил бүр
		100,000,001.00-200,000,000.00 төгрөг хүртэл бол	300,000.00 төгрөг Жил бүр
		10,000,001.00-100,000,000.00 төгрөг хүртэл бол	150,000.00 төгрөг Жил бүр
<b>ХОЁР. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ</b>			
2.1	Улаанбаатар хотод салбар нээх зөвшөөрөл	200,000.00 төгрөг	Тухай бүр
2.2	Орон нутагт салбар нээх зөвшөөрөл	20,000.00 төгрөг	Тухай бүр
2.3	Тусгай зөвшөөрлийг сэргээх	100,000.00 төгрөг	Тухай бүр
2.4	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000.00 төгрөг	Тухай бүр

----- о о о -----

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 158 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНООС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ**


	Зохицуулалттай үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
<b>НЭГ. Тусгай зөвшөөрөл</b>			
1.1	Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа	Нийт активын дүнгийн 0.03 хувьтай тэнцүү /дээд хэмжээ 2,000,000.00 төгрөг, доод хэмжээ 20,000.00 төгрөг/	Жил бүр
<b>ХОЁР. Хуульд заасан бусад зөвшөөрөл</b>			
2.1	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ	150,000.00 төгрөг	Тухай бүр
2.2	Төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ	100,000.00 төгрөг	Тухай бүр
2.3	Цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах үйлчилгээ	100,000.00 төгрөг	Тухай бүр
<b>ГУРАВ. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ</b>			
3.1	Оноосон нэр өөрчлөх	500,000.00 төгрөг	Тухай бүр
3.2	Тусгай зөвшөөрлийг сэргээх	100,000.00 төгрөг	Тухай бүр
3.3	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000.00 төгрөг	Тухай бүр



Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01-ний  
өдрийн 158 дугаар тогтоолын тавдугаар хавсралт

## **ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл.**



1.1. Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтын дагуу санхүүгийн зах зээлд ажиллаж буй тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооноос хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс /цаашид “хөлс” гэх/-ийг төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

### **Хоёр. Хөлс төвлөрүүлэх хэлбэр**

2.1. Хөлсийг дараах үндсэн 3 хэлбэрээр төвлөрүүлнэ:

2.1.1. “хувь тооцож төвлөрүүлэх” гэж орлого, арилжаа болон нийт активын дүнгээс хувиар тооцсон дүнгээр жил бүр төвлөрүүлэхийг ойлгоно.

2.1.2. “тогтоосон хэмжээгээр төвлөрүүлэх” гэж Хорооноос тогтоосон хэмжээ, ангилал, хуваарийн дагуу жил бүр төвлөрүүлэхийг ойлгоно.

2.1.3. “тухай бүр тогтоосон хэмжээгээр төвлөрүүлэх” гэж хөлс төлөх үүрэг бүхий этгээд Хорооноос тогтоосон төрөл, хэмжээгээр тухайн үед гүйцэтгэсэн ажлын дүнд нэг удаа төвлөрүүлэхийг ойлгоно.

### **Гурав. Хөлс төвлөрүүлэх хугацаа, хөнгөлөх нөхцөл**

3.1. Хувь тооцож төвлөрүүлэх болон тогтоосон хэмжээгээр төвлөрүүлэх хөлсийг даатгалын байгууллагын хувьд жил бүр 2 тэнцүү хувааж эхний төлбөрийг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, дараагийн төлбөрийг 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлнэ.

3.2. Хувь тооцож төвлөрүүлэх хөлсийг үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн хувьд арилжаа хийгдсэн тухай бүр, хөдөө аж ахуйн биржийн зуучлагчийн хувьд тухайн 7 хоногийн нийт арилжааны дүнгээс тооцож дараа 7 хоногийн Мягмар гаригт багтаан тогтоосон хувиар тооцож төвлөрүүлнэ.

3.3. Жил бүр төвлөрүүлэх хөлсийг “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох, төвлөрүүлэх журам” батлах тухай тогтоолын 1, 2, 3, 4 дүгээр хавсралтуудад заасны дагуу жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлнэ.

3.4. Хорооноос үйлчилгээ үзүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хөлс төлөх үүрэг бүхий этгээд нь тухай бүр төвлөрүүлэх хөлсийг шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногт багтаан төлнө.

3.5. Банк бус санхүүгийн байгууллага нь Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг, аймгийн төвийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бол жил бүр төвлөрүүлэх хөлсний 10 хувь, аймгийн төвөөс бусад суманд үйл ажиллагаа явуулж байгаа бол 20 хувь, Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны гишүүн бол 10 хувийн хөнгөлт тус тус эдэлнэ.

3.6. Хадгаламж, зээлийн хоршооны нийт активын дүн 300.0 сая төгрөгөөс доош бөгөөд Монголын Хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбооны гишүүн бол жил бүр төвлөрүүлэх хөлснөөс чөлөөлөгдөнө.

3.7. Хөлсийг Төрийн сан банкин дахь Хорооны 900025001 тоот дансанд төвлөрүүлнэ.

#### **Дөрөв. Хариуцлага.**

4.1. Хөлсийг тогтоосон хугацаанд бүрэн төвлөрүүлээгүй, хугацаа хожигдуулж төвлөрүүлсэн хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----- о 0 о -----